

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД, ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2019 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/42 / А/47

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэгт заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. "Хоригдсон этгээдэд эмнэлгийн тусламж үзүүлэх, түүнийг эмнэлгийн байгууллагад эмчлэх, хорих байранд эмнэлгийн мэргэжилтэн ирж, үйлчлэх журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Б.Бямбадорж/, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Г.Билгүүн/ нарт даалгасугай.

3. Энэхүү тушаалаар батлагдсан журмыг баримтлан ажиллахыг Улсын ерөнхий прокурорын газар /Төрийн хууль цаазын тэргүүн зөвлөх М.Энх-Амгалан/, Авлигатай тэмцэх газрын дарга /Тэргүүн комиссар Х.Энхжаргал/, Тагнуулын ерөнхий газрын дарга /Д.Гэрэл/ нарт зөвлөж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /хурандаа Д.Дамдинцэрэн/, Цагдаагийн ерөнхий газрын дарга /хурандаа С.Баатаржав/ нарт даалгасугай.

4. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэнд, спортын сайд, Хууль зүйн сайдын хамтарсан 2016 оны 59/А/67 дугаар, Эрүүл мэндийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан 2017 оны А/29/А/12 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД



Д.САРАНГЭРЭЛ

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙД



Ц.НЯМДОРЖ

Эрүүл мэндийн сайд, Хууль зүй,
дотоод хэргийн сайдын хамтарсан
... оны ... дугаар сарын ... ны
өдрийн ... дугаар тушаалын
хавсралт

**ХОРИГДСОН ЭТГЭЭДЭД ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ, ТҮҮНИЙГ ЭРҮҮЛ
МЭНДИЙН БАЙГУУЛЛАГАД ЭМЧЛЭХ, ХОРИХ БАЙРАНД ЭМНЭЛГИЙН
МЭРГЭЖИЛТЭН ИРЖ ҮЙЛЧЛЭХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг зүйл

1.1. Нийслэл дэх цагдан хорих төв, баривчлах байр, аймгийн цагдан хорих байр, баривчлах байр /цаашид "хорих байр" гэх/-нд баривчлагдсан, цагдан хоригдсон этгээд /цаашид "хоригдсон этгээд" гэх/-д эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, түүнийг эрүүл мэндийн байгууллагад эмчлэх, хорих байранд эмнэлгийн мэргэжилтэн ирж үйлчлэхтэй холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Хоригдсон этгээдэд энэ журамд заасан эмнэлгийн тусламж, үйлчилгээг Нийслэл дэх цагдан хорих төвийн эмнэлэг, аймгийн Нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Тусгай эмнэлэг, Тусгай мэргэжлийн төв, Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг үзүүлнэ.

1.3. Хоригдсон этгээдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Эрүүл ахуйн тухай хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан тогтоол, журмыг мөрдөнө.

**Хоёр. Хоригдсон этгээдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээ
үзүүлэх, эрүүл мэндийн үзлэг хийх**

2.1. Хоригдсон этгээдийг хорих байранд хүлээн авах, цагдан хорих нэг байрнаас нөгөөд шилжих болон эмнэлгийн тусламж, авах зайлшгүй шаардлагын улмаас эмнэлгийн байгууллагад шилжүүлэх, суллах, таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх, түүнчлэн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоор түр хугацаагаар гарах, ирэх тохиолдол бүрт тухайн хорих байрны эмнэлгийн мэргэжилтэн эрүүл мэндийн үзлэг /шарх, сорви, гэмтэл, сэтгэц, биеийн жин, өндөр/ хийж, өвчлөлийн талаар асууж, эрүүл мэндийн байдлыг тодорхойлон, эрүүл мэндийн дэвтэрт тэмдэглэж, хувийн хэрэгт нь хавсаргана.

2.2. Архаг өвчтэй, удаан хугацааны эмчилгээ шаардлагатай байгаа хоригдсон этгээдэд тухайн хорих байрны эмнэлгийн мэргэжилтэн өдөр бүр эрүүл мэндийн үзлэг хийж, эмийн хангамж, хэрэглээнд хяналт тавьж, эрүүл мэндийн дэвтэрт тэмдэглэл үйлдэнэ.

2.3. Хорих байрны эмнэлгийн мэргэжилтэн нь хоригдсон этгээдийн эмнэлгийн тусламж авах хүсэлтийн дагуу цаг алдалгүй, эрүүл мэндийн үзлэг хийж, шаардлагатай оношилгоо, эмчилгээнд хамруулна.

2.4. Хорих байрны эмнэлгийн мэргэжилтэн нь хорих байрны эрүүл ахуй, хоол хүнсний боловсруулалт, илчлэг, амт, чанарт өдөр бүр хяналт тавьж, хоолны дээжийг холбогдох журам, зааврын дагуу хадгалж, устгана.

2.5. Хоригдсон этгээдэд хоногт олгож буй хоолны дээжийг улирал тутамд шинжилгээнд өгч, илчлэгийг тодорхойлуулах бөгөөд хууль тогтоомжид заасан хэмжээнд хүрээгүй бол нэмэгдүүлэх арга хэмжээ авна. Хоолны илчлэг тодорхойлуулсан баримтыг хорих байрны санхүүд хадгална.

2.6. Сахилгын өрөөнд хоригдож байгаа этгээдэд хорих байрны эмнэлгийн мэргэжилтэн өдөр бүр эрүүл мэндийн үзлэг хийж, тэмдэглэл хөтөлж, тэмдэглэлийг хувийн хэрэгт хавсаргана.

2.7. Сахилгын өрөөнд хоригдож байгаа этгээдийг эрүүл мэндийн хувьд уг өрөөнд байлгах боломжгүй нь хорих байрны эмнэлгийн мэргэжилтний үзлэгээр тогтоогдвол хорих байрны захиргаа тухайн этгээдийг сахилгын өрөөнөөс хорих өрөөнд шилжүүлж, эмнэлгийн тусламж авах боломжийг даруй бүрдүүлнэ.

2.8. Хорих байрны захиргаа нь алба хаагчдад анхан шатны эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээ үзүүлэх дадал, чадвар олгох сургалтыг эрүүл мэндийн байгууллага болон мэргэжлийн төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулна.

2.9. Хоригдсон этгээдэд эмнэлгийн анхны тусламж болон амь тэнсэх үеийн тусламж, үйлчилгээг хорих байрны эмнэлгийн мэргэжилтэн үзүүлнэ.

2.10. Хорих байр нь үзлэг, оношилгоо, тусламж, үйлчилгээ үзүүлэх халдвар хамгааллын шаардлагад нийцсэн өрөө, яаралтай тусламж үзүүлэхэд шаардагдах эм, эмнэлгийн багаж хэрэгсэл, эмийн байнгын нөөцтэй байна.

2.11. Аймаг, орон нутагт хоригдсон этгээдийг эмнэлгийн мэргэжилтний үзлэг, дүгнэлт, хорих байрны захиргаа, мөрдөгч, прокурорын саналыг үндэслэн шүүгчийн шийдвэрээр Нийслэл дэх цагдан хорих төвийн эмнэлэгт шилжүүлэн эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлж болно.

2.12. Хоригдсон этгээд өлсгөлөн зарласны улмаас амь насанд нь аюул учирч болзошгүй тохиолдолд "Өлсгөлөн зарласан үед эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх заавар"-ыг баримтлан арга хэмжээ авна.

Гурав. Хоригдсон этгээдийг эрүүл мэндийн байгууллагад шилжүүлэн эмчлэх, хорих байранд эмнэлгийн мэргэжилтэн ирж үйлчлэх

3.1. Хорих байрны эмнэлгийн мэргэжилтний үзлэгээр хоригдсон этгээдэд Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн тусламж, үйлчилгээ шаардлагатай нь тогтоогдвол хорих байрны дарга аймгийн Нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт эмчлүүлэх саналаа прокурорт хүргүүлнэ.

3.2. Нийслэл дэх цагдан хорих төвийн эмнэлэг, аймгийн Нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвөөс хоригдсон этгээдийг яаралтайгаар Тусгай

мэргэжлийн төв, Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт шилжүүлэхдээ төрөлжсөн мэргэшлийн эмчийн үзлэг, дүгнэлтийг үндэслэнэ.

3.3. Гэнэтийн цочмог өвчин эмгэг, осол, гэмтэл, хордлого, жирэмсэн, төрөх, амь тэнссэн үед хорих байрны эмнэлгийн мэргэжилтэн, алба хаагч ойролцоох эрүүл мэндийн байгууллагад даруй хуяглан хүргэх эсхүл түргэн тусламжийн үйлчилгээг дуудна. Түргэн тусламжийн үйлчилгээг ирэх хүртэл, эсхүл хуяглан хүргэх явцад анхан шатны тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

3.4. Энэ журмын 3.3-д заасан дуудлагыг үндэслэн эмнэлгийн мэргэжилтэн хоригдсон этгээдэд тусламж, үйлчилгээ үзүүлэхээр ирэхэд хорих байрны дарга нэвтрэх зөвшөөрлийг шуурхай олгоно.

3.5. Нийслэл дэх цагдан хорих төвийн эмнэлгийн дуудлагаар төрөлжсөн мэргэшлийн эмч тусламж, үйлчилгээ үзүүлнэ.

3.6. Хоригдсон этгээдэд яаралтайгаас бусад тохиолдолд төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн тусламж, үйлчилгээ шаардлагатай эсэхийг орон нутагт аймгийн Нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн эмч нарын зөвлөгөөний шийдвэр, нийслэлд Хорих ял эдлүүлэх албаны нэгдсэн эмнэлгийн эмнэлэг хяналтын комисс шийдвэрлэнэ. Тухайн шийдвэрийг хорих байрны захиргаа холбогдох мөрдөгч, прокурор, шүүгчид тухай бүрд нь мэдэгдэж, шаардлагатай эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлнэ.

3.7. Хоригдсон этгээдийг аймгийн Нэгдсэн эмнэлэг болон Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн сэхээн амьдруулах, эрчимт эмчилгээний тасгаас бусад тасагт хэвтүүлэн эмчлэх тохиолдолд бусад үйлчлүүлэгчдээс тусгаарлан, эрүүл ахуйн шаардлага хангасан өрөөнд хэвтүүлэн эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх ба цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ өөрчлөгдөөгүй бол харуул хамгаалалтыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хариуцан, зохион байгуулна.

3.8. Эмчлүүлж буй хоригдсон этгээдийн биеийн байдал хүнд буюу тусгайлан асаргаа шаардлагатай бол эмч нарын зөвлөгөөний шийдвэрийг үндэслэн прокурорын бичгээр өгсөн зөвшөөрлөөр сахиуртай байлгаж болно.

3.9. Эмчлүүлж буй хоригдсон этгээдийн хэвтүүлэн эмчлэх хугацааг сунгах, эмнэлэг хооронд болон эмнэлэг дотроо тасаг хооронд шилжүүлэх эсэхийг тухайн эмнэлгийн эмч нарын зөвлөгөөнөөр шийдвэрлэж, энэ тухай хорих байрны захиргаанд мэдэгдэнэ.

3.10. Эмчлүүлж буй хоригдсон этгээдэд цагдан хорихоос бусад төрлийн таслан сэргийлэх арга хэмжээ авах, түүнчлэн эрх бүхий албан тушаалтны зөвшөөрлөөр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоор түр хугацаагаар гарах, ирэх тохиолдолд эмчлэгч эмч эрүүл мэндийн үзлэг хийж, өвчний түүхэд бичилт хийнэ. Эрх бүхий этгээд холбогдох материалыг хувийн хэрэгт хавсаргана

3.11. Амьсгалын замын болон зоонозын халдварын сэжигтэй нь оношлогдон, эмчлүүлж буй хоригдсон этгээдийн харуул хамгаалалтыг гүйцэтгэж байгаа алба

хаагчийн эрүүл мэндийн аюулгүй байдлыг тухайн эрүүл мэндийн байгууллага хангана.

3.12. Эмнэлгийн байгууллага нь эмнэлгийн тусламж, үйлчилгээнд хамрагдаж байгаа хоригдсон этгээдэд зохих журмын дагуу харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэх нөхцөл, бололцоог хангаж өгөх ба үүрэг гүйцэтгэж буй алба хаагч эрүүл мэндийн байгууллагаас үзүүлж байгаа үйлчилгээнд саад учруулахгүй, эмнэлгийн дотоод журмыг мөрдөнө.

3.13. Эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа хоригдсон этгээдтэй эрх, үүрэг бүхий эмнэлгийн эмч, ажилтнаас бусад хүмүүсийг зөвхөн хорих санал, шийдвэр гаргасан байгууллага, албан тушаалтны бичгээр өгсөн зөвшөөрлийн дагуу уулзалт хийлгэнэ.

Дөрөв. Бусад зүйл

4.1. Хоригдсон этгээд хуурамчаар өвчилсөн, эрүүл мэнд болон бие эрхтэндээ санаатайгаар өөрөө гэмтэл учруулсан бол эмчилгээний зардлыг хувиас нь нөхөн төлүүлнэ.

4.2. Хорих байр нь лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллах гэрээг хууль тогтоомж, энэ журмын хүрээнд байгуулж болно.

4.3. Хоригдсон этгээдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэхээр ирсэн эмнэлгийн мэргэжилтний аюулгүй байдлыг хорих байрны захиргаа хариуцна.

4.4. Шаардлагатай тохиолдолд хоригдсон этгээдэд эмнэлгийн тусламж үзүүлэх, түүнийг эрүүл мэндийн байгууллагад хэвтүүлэн эмчлүүлэх хугацаанд харуул хамгаалалтыг зохион байгуулахад цагдаагийн байгууллагатай хамтран ажиллаж болно.

4.5. Хорих байрны захиргаа нь энэ журмын 3.3, 3.9 дэх хэсэгт заасныг мөрдөгч, прокурор, шүүгчид тухай бүр мэдэгдэж, тэмдэглэл үйлдэнэ.

4.6. Хорих байранд онцгой дэглэм тогтоосон үед эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг энэ журмын 3.3-д заасны дагуу хэрэгжүүлнэ.

----oOo----